110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,331,100	156,800
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	34,889,100	34,055,481.14
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	62,024,700	52,636,712.4
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,514,700	450,482.4
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	510,000	524,000
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	59,000,000	51,662,230
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	35,365,800	33,778,225
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,465,800	1,874,463
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	1,365,800	454,463
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100,000	0.0
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,000,000	1,420,000
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	2,500,000	1,854,872
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	2,500,000	1,854,872
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,400,000	30,048,890
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	24,400,000	29,197,750
118204	3.1.01.1.1.8.3.04 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.0	851,140
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,036,000,000	1,025,128,941
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	79,255,200	68,386,541
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	20,000,000	8,014,300
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого / үндсэн/	20,452,500	57,014,861
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	39,105,000	0.0

120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0.0	3,357,380
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	816,369,200	816,369,200
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	816,369,200	816,369,200
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	140,373,300	140,373,200
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	140,373,300	140,373,200
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,816,938,700	1,655,615,479.46
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,342,519,400	1,296,461,910.46
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,325,259,400	1,287,597,910.46
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,130,800	835,865,470.43
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	785,192,600	479,472,165.53
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	0.0	337,193,560.32
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	20,043,500	16,816,948.4
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	33,894,700	2,382,796.18
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,169,300	104,194,688
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	73,616,100	72,953,396
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	7,888,400	7,810,472
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	3,944,200	3,905,188
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	3,944,200	3,905,188
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	15,776,400	15,620,444
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,330,800	267,451,900.61
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	34,547,800	33,962,250.61
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	229,036,200	231,233,650
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	8,746,800	2,256,000
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	29,312,800	19,137,351.42
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	3,986,800	3,247,051.42
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	16,084,200	12,148,500
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,555,200	1,659,300
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,775,000	1,732,500
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	911,600	350,000
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,800,000	0.0
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000	0.0
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	11,592,100	8,363,600
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	2,858,500	0.0
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	8,733,600	8,363,600
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	7,814,100	7,427,100
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	7,814,100	7,427,100

2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,992,900	5,532,000
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	816,900	305,000
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	716,000	0.0
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	120,000	0.0
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	160,000	0.0
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000	77,000
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,050,000	5,150,000
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	50,000	0.0
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	50,116,600	39,625,800
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	30,593,000	26,264,600
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,523,600	13,361,200
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,260,000	8,864,000
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	17,260,000	8,864,000
213208	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260,000	7,260,000
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000	1,604,000
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	374,419,300	299,153,569
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	374,419,300	299,153,569
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000,000	60,000,000
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	100,000,000	60,000,000
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	315,941.000	-190,545,336.9
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-315,941.000	190,545,336.9
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-315,941.000	190,545,336.9
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	318,267,894.55
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	127,722,557.65
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	58
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	6.1.01 Төсвийн байгууллага	2	2
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28
620001	6.2.01 Удирдах ажилтан	8	8
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	3	3
620004	6.2.04 Гэрээт ажилтан	6	6

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	280,389,597
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,389,597
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	280,389,597
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	280,389,597
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	280,389,597
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	267,295,432
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,094,165
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	277,032,217
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	82,936,785
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,936,785
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500
210101	1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	514,500
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,167
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	59,167
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,116,918
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,116,918
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	5,361,400
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	5,361,400
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	3,500,000
210702	1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт	3,500,000
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	72,384,800
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	70,385,000
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,999,800
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	194,095,432
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	194,095,432
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	194,095,432
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,357,380
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-3,357,380
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-3,357,380

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын мөрдөж байгаа мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 127.7 сая төгрөг болж, өмнөх оноос 190.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	318.3	127.7	-190.6	59.9

Дүн

318.3

127.7

-190.6

59.9

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 127.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 202.6 сая, эцсийн үлдэгдэл 208.6 сая төгрөг болж, 6.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	7.9	8.4	0.5
Ажиллагсадтай холбоотой авлага	0	0.7	0.7
Байгууллагаас авах авлага	0	0.0	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	71.5	56.6	-14.9
Зээлийн авлага	123.2	142.9	19.7
Дүн	202.6	208.6	6.0

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 208.6 сая төгрөг болж 6.0 сая төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн авлага өссөнөөс шалтгаалжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 84.6 сая, эцсийн үлдэгдэл 51.7 сая төгрөг болж, 32.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	2.9	3.5	0.6
Аж ахуйн материал	34.5	26.7	-7.8
Сэлбэг хэрэгсэл	3.4	1.1	-2.3
Түлш шатах тослох материал	12.0	0.1	-11.9
Хүнсний материал	0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	23.9	16.4	-7.5
Мал амьтад	7.9	3.9	-4.0
Дүн	84.6	51.7	-32.9

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 51.7 сая төгрөг болж 32.9 сая төгрөгөөр буурсан нь түлш шатах тослох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал буурсантай холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,150.7 сая, эцсийн үлдэгдэл 1,578.8 сая төгрөг болж, 428.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	748.9	1,137.4	338.5
Хуримтлагдсан элэгдэл	-251.2	-298.4	-47.2
Авто тээврийн хэрэгсэл	122.4	149.6	27.2
Хуримтлагдсан элэгдэл	-40.3	-58.7	-18.3

Машин тоног төхөөрөмж (компьютер)	235.6	210.7	-24.9
Хуримтлагдсан элэгдэл	-147.1	-141.1	5.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	56.3	56.5	0.2
Хуримтлагдсан элэгдэл	-48.9	-48.4	0.5
Зам гүүрний барилга байгууламж	0.0	0.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	1,063.1	1,159.4	96.3
Хуримтлагдсан элэгдэл	-609.9	-614.9	-5.0
Ном	0.0	0.0	0.0
Программ хангамж	2.0	7.0	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-2.0	-2.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	21.9	21.9	0.0
Хуримтлагдсан элэгдэл			
Дүн	1,150.7	1,578.8	428.2

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,578.8 сая төгрөг болж 428.2 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламж болон бусад үндсэн хөрөнгө дансанд шинээр хөрөнгө нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.4 сая, эцсийн үлдэгдэл 39.9 сая төгрөг болж, 39.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Байгууллагад төлөх өглөг	0.4	39.9	39.5	9875
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.0	0.0	0.0
Нийт дүн	0.4	39.9	39.5	9875

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 39.9 сая төгрөг болж 39.5 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг өссөнөөс шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,755.7 сая, эцсийн үлдэгдэл 1,927.0 сая төгрөг болж, 171.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын өмчлөн эзлэн нутгийн сан/	475.5	475.5	0.0	0
Хуримтлагдсан үр дүн	1,025.5	1,196.8	171.3	16.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	254.7	254.7	0.0	0
Дүн	1,755.7	1,927.0	171.3	9.7

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,927.0 сая төгрөг болж 171.3 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 1,196.8 сая төгрөг болж 171.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд Завхан суманд татварын орлого 439.9 сая, нийтлэг татварын бус орлого 614.5 сая, тусламжийн орлого 2,445.4 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг /ОНХНС/ 140.4 нийт 3,640.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын аудитаар нийт 1,360.1 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 1,358.8 сая төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж, 1.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгсөн.

Аудитын илрүүлэлт:

Завхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- ✓ Завхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 78.5 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 7.1 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 16 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.

Завхан сумын Засаг даргын тамгын газар:

- ✓ Завхан сумын Засаг даргын 2025 оны А/13, А/19 дүгээр захирамжаар бэлэг дурсгалын зүйлд 1.3 сая төгрөг зарцуулсан зөрчилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх албан шаардлага өгсөн.
- ✓ Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 0.7 сая төгрөгийн 2 гүйлгээ хийсэн зөрчилд зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.
- ✓ Шилэн дансны цахим хуудаст Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 733.3 сая төгрөгийн орлогын 10 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 255.3 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 248.0 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 37 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.
- ✓ Завхан сумын Засаг даргын тамгын газрын нярвын дансаар дамжуулан 35.9 сая төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан зөрчилд байгууллагын нярвын хувийн дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг 2,294.2 сая төгрөгөөр тооцож санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 453.9 сая, төсвийн дэмжлэгээр 944.4 сая, урд оны үлдэгдлээс 43.3 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 510.4 сая, урьд оны үлдэгдлээс 151.8 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 100.4 сая, өвс тэжээлийн эргэн төлөлтөөс 90.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Завхан сумын 2025 оны төсвийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 3/06 дугаар тогтоолоор 2,294.2 сая төгрөгөөр баталж 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 6/02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 477.3 сая төгрөгөөр бууруулж 1,816.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,816.9 сая төгрөгийн төсөв баталснаас сумын татварын болон татварын бус орлогоос 484.7 сая, урд оны үлдэгдлээс 100.0 сая, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 816.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 140.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн урд оны үлдэгдлээс 135.9 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 100.4 сая, өвс тэжээлийн эргэн төлөлтөөс 39.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 439.9 сая, татварын бус орлого 8.0 сая, төсөвт байгууллагын өрийн орлого 57.0 сая, бусад орлого 3.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 140.4 сая, тусламжийн орлого 816.4 сая, нийт 1,465.1 сая төгрөгийн эх үүсвэр тайлант онд бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,655.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Зөрүү 190.5 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,655.6 сая төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь зардлыг 8.4 сая төгрөгөөр хэмнэж, татварын орлогын төлөвлөгөө 92.4 хувиар биелж 127.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Завхан сумын ИТХ-ын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай 2025 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн 6/02 дугаар тогтоолоор Завхан сумын төвлөрүүлэн захирагч тайлант онд 484.7 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 447.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 92.4 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/сая.төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл		Нийт дүн
		Завхан ИТХ	Завхан ЗДТГ	
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	2.0	3.0	5.0
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	0.0	0.0	0.0
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0.0	0.0	0.0
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	0.0	0.0
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	0.0	0.0
6	Байгууллагын орон тоо	7	21	28
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай	0.0	0.0	0.0

байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл			
---	--	--	--

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 267.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13.1 сая, нийт 280.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 277.0 сая төгрөгийг зарцуулж 3.4 сая төгрөгийг төгрөгийг зарцуулах эрх хязгаарласнаас шалтгаалан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,166.0 сая төгрөгийн 1 хувь буюу 31.7 сая

төгрөгөөс 80 хувиар тооцож 25.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 181 мэдээллээс хугацаандаа оруулсан 144, байршуулаагүй 22 хугацаа хоцроож 12 мэдээллийг байршуулсан ба хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 240.5 сая төгрөгийн орлогын 13 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 118.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, 281.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 7 шийдвэр, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Завхан Засаг дарга	1	640.3					1	640.3
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	640.3					1	640.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б. АВИРМЭД/



2026 оны 03 сарын 20-ны өдөр